ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 11 сарын 19 өдөр Дугаар А/72 Чойр

Эмнэлгийн тусламж үйлчилгээнд ашиглах
орны дээд хязгаарыг батлах тухай

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвснэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2014 оны "Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын үлгэрчилсэн дүрэм, үйл ажиллагааны чиглэл батлах тухай" 415 дугаар тушаалын 2.3 дахь хэсэг, 2019 оны "Улсын хэмжээнд 2020-2021 онд эмнэлгийн тусламж үйлчилгээнд ашиглах орны дээд хязгаарыг батлах тухай" А/479 дүгээр тушаалуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2020-2021 онд аймгийн хэмжээнд Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд ашиглах орны дээд хязгаарыг нэгдүгээр, харьяа эрүүл мэндийн байгууллагуудын орны дээд хязгаарыг хоёрдугаар, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын орны дээд хязгаарыг гуравдугаар хавсралтаар тус тус батласугай.

2.Батлагдсан орны дээд хязгаарт багтаан хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулан орны фонд ашиглалтыг оновчтой зохион байгуулж ажиллахыг харьяа эрүүл мэндийн байгууллагуудын дарга нарт даалгасугай

3. Тушаалын хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтэс /Л.Удвал/-т, хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөлт, санхүү үйлчилгээний хэлтэс /Д.Нарансолонго/-т даалгасугай

ДАРГА Ц.МӨНХ-ОД

D:\tushaal 2019\Tushaal.doc

08000243

Эрүүл мэндийн газрын даргын
2019 оны 11 сарын 19-ны өдрийн
А/72 дугаар тушаалын хавсралт

## АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД 2020-2021 ОНД АШИГЛАХ ОРНЫ ДЭЭД ХЯЗГААР

| Говьсүмбэр | Өдрийн эмчилгээний орны дээд хязгаар / А/ | Эмнэл зүйн эрт үеийн эмнэлгийн цогц тусламж, үйлчилгээний нэр | | | | Өвчний удаан явц,архаг үеийн дагнасан тусламж үйлчилгээний ор | | | | | | | Хэвтүүлэн Эмчлэх Орны дээд хязгаар /Г=Б+В/ | НИЙТ ОР / А + Г / |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Өвчний хурц цочмог үеийн ор | Өвчний хурцавтар /цочмогдуу/ үеийн ор | Сүрьеэгийн ор | Бүгд /Б/ | Уламжлалтын ор | Сувилахуйн ор | Хөнгөвчлөх асаргаа сувилагааны ор | Сэргээн засахын ор | Сувиллын ор | Сэтгэцийн ор | Бүгд / В/ | | |
| Аймгийн хэмжээнд | 16 | 62 | 25 | 3 | 90 | 30 | 8 | 4 | 30 | 30 | 4 | 106 | 196 | 246 |
| Шивээговь, Баянтал сумдын ЭМТ | 4 | 22 | 7 | - | 30 | | | | | | | | 30 | |

Эрүүл мэндийн газрын даргын
2019 оны 11 сарын 19-ны өдрийн
А/70 дугаар тушаалын хавсралт

# ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД 2020-2021 ОНД АШИГЛАХ ОРНЫ ДЭЭД ХЯЗГААР

| Говьсүмбэр | Өдрийн эмчилгээний орны дээд хязгаар / А/ | Эмнэл зүйн эрт үеийн эмнэлгийн цогц тусламж, үйлчилгээний нэр | | | | Өвчний удаан явц,архаг үеийн дагнасан тусламж үйлчилгээний ор | | | | | | | Хэвтүүлэн Эмчлэх Орны дээд хязгаар /Г=Б+В/ | НИЙТ ОР / А + Г / |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Өвчний хурц цочмог үеийн ор | Өвчний хурцавтар /цочмогдуу/ үеийн ор | Сүрьеэгийн ор | Бүгд /Б/ | Уламжлалтын ор | Сувилахуйн ор | Хөнгөвчлөх асаргаа сувилагааны ор | Сэргээн засахын ор | Сувиллын ор | Сэтгэцийн ор | Бүгд / В/ | | |
| Аймгийн Нэгдсэн эмнэлэг | 16 | 62 | 25 | 3 | 90 | 15 | 3 | 4 | 10 | | 4 | 36 | 126 | 142 |
| Шивээговь сумын ЭМТ | 2 | 14 | 4 | - | 18 | 2 | | | 2 | | | 4 | 22 | 24 |
| Баянтал сумын ЭМТ | 2 | 8 | 4 | - | 12 | 2 | | | 2 | | | 4 | 16 | 18 |

Эрүүл мэндийн газрын даргын
2019... оны ..12 сарын ..10-ны өдрийн
№ 20.. дугаар тушаалын хавсралт

## ХУВИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД 2020-2021 ОНД АШИГЛАХ ОРНЫ ДЭЭД ХЯЗГААР

| Говьсүмбэр | Өдрийн эмчилгээний орны дээд хязгаар /А/ | Эмнэл зүйн эрт үеийн эмнэлгийн цогц тусламж, үйлчилгээний нэр | | | | Өвчний удаан явц,архаг үеийн дагнасан тусламж үйлчилгээний ор | | | | | | Хэвтүүлэн Эмчлэх Орны дээд хязгаар /Г=Б+В/ | НИЙТ ОР |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Өвчний хурц цочмог үеийн ор | Өвчний хурцавтар /цочмогдуу/ үеийн ор | Сүрьеэгийн ор | Бүгд /Б/ | Уламжлалтын ор | Сувилахуйн ор | | Сэргээн засахын ор | Сувиллын ор | Бүгд / В/ | | |
| Сэргээн засах төв | | | | | | | | | 16 | | 16 | | 16 |
| Сувилахуйн төв | | | | | | | 5 | | | | 5 | | 5 |
| Сувилал | | | | | | | | | | 30 | 30 | | 30 |
| Уламжлалын хувийн эмнэлэг | | | | | | 11 | | | | | 11 | | 11 |
| Нийт ор | | | | | | | | | | | | | 62 |